



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА/2025/002/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn Аудитын менежер: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Жалбаа Утас: 89330330 Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Уднстай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫН ДАРГА С.НЯМЖАВТ

Радс.04.01 № 410
тагай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийгмийн даатгалын сангийн тайланд тэтгэвэр, тэтгэмжийг илүү олгосонтой холбоотой 336.6 сая төгрөгийн авлага бүртгэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шинэ программ нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн бөгөөд уг программын хэвийн ажиллах нөхцөл бүрдээгүйгээс санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд иж бүрэн гаргаж ирүүлээгүй байна.

Нийгмийн даатгалын сангийн 2024 жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт эксел хэлбэрээр ирүүлсэн бөгөөд аудитын явцад санхүүгийн тайланг программаар гарган санхүүгийн тайлан, тодруулгад залруулга хийсэн болно.

Бусад асуудлын хэсэг

D/diek/Албан бичиг/Дүгнэлт-2025

812502587

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,955,266,775.79	13,677,065,647.28
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,507,631,411.08	11,310,925,512.56
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,507,631,411.08	11,310,925,512.56
31210	Төгрөг	8,507,631,411.08	11,310,925,512.56
31213	Арилжааны банк дахь харилцах	8,507,611,933.83	11,310,925,512.56
33	АВЛАГА	2,447,635,364.71	2,366,140,134.72
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	869,880,148.40	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,153,461,389.48	1,147,753,089.48
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.00	692,124,552.23
33500	Бусад авлага	424,293,826.83	526,262,493.01
33510	Байгууллагаас авах авлага	424,293,826.83	146,068,443.87
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	380,194,049.14
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,955,266,775.79	13,677,065,647.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	554,150,645.57	1,184,754,875.76
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	554,150,645.57	1,184,754,875.76
41300	Өглөг	88,978,987.76	435,003,740.41
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	88,978,987.76	0.00
41360	Бусад өглөг	0.00	435,003,740.41
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	138,306,002.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	285,639,332.07
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	0.00	11,058,406.34
41400	Урьдчилж орсон орлого	465,171,657.81	749,751,135.35
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	465,171,657.81	749,751,135.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,401,116,130.22	12,492,310,771.52
51	Засгийн газрын хувь оролцоо	10,401,116,130.22	12,492,310,771.52
51200	Хуримтлагдсан үр дүн	10,401,116,130.22	12,492,310,771.52
51210	Өмнөх үеийн үр дүн	8,536,467,155.67	10,251,896,982.64
51220	Тайлант үеийн үр дүн	1,864,648,974.55	2,240,413,788.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,955,266,775.79	13,677,065,647.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	192,376,812,824.55	160,278,811,005.75
11	ТАТВАРЫН ОРЛОГО	38,593,060,766.99	43,581,464,686.79
110	Орлогын албан татвар	0.00	0.00
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	38,593,060,766.99	43,581,464,686.79
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	26,823,667,876.22	36,727,516,983.30

112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,794,681,242.80	3,810,774,070.18
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,758,154,113.16	1,791,713,228.08
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	527,741,105.28	1,251,460,405.23
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,688,816,429.53	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	656,339,344.82	136,721,134.45
120	Нийтлэг татварын бус орлого	656,339,344.82	136,721,134.45
120002	Хүүгийн орлого	49,967,524.76	55,398,834.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,922,025.06	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,922,025.06	0.00
120009	Бусад орлого	557,449,795.00	81,322,299.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	153,127,412,712.74	116,560,625,184.51
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13,758,681,305.00	28,594,598,134.51
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,758,681,305.00	28,594,598,134.51
1330	Төсвийн захирагчдаас	139,368,731,407.74	87,966,027,050.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	139,368,731,407.74	87,966,027,050.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	190,512,163,850.00	158,038,397,216.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	190,512,163,850.00	158,038,397,216.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,804,830.00	8,349,680.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,804,830.00	8,349,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1,320,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,804,830.00	7,029,680.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	190,505,359,020.00	158,030,047,536.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	88,949,897,453.00	114,219,645,519.03
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	88,949,897,453.00	114,219,645,519.03
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	101,555,461,567.00	43,810,402,017.84
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,555,461,567.00	43,810,402,017.84
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,864,648,974.55	2,240,413,788.88
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,864,648,974.55	2,240,413,788.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	193,624,732,989.54	169,123,240,937.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	38,145,446,081.72	52,708,690,105.74
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	38,145,446,081.72	52,708,690,105.74

112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	26,527,760,861.90	37,469,007,064.51
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,763,135,745.23	3,814,791,842.11
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,734,587,120.87	2,185,470,915.35
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	519,218,923.13	1,244,696,602.63
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,600,743,430.59	7,994,723,681.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	322,885,700.08	224,673,381.76
120	Нийтлэг татварын бус орлого	322,885,700.08	224,673,381.76
120002	Хүүгийн орлого	38,886,972.63	66,135,832.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	283,998,727.45	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	283,998,727.45	0.00
120009	Бусад орлого	0.00	158,537,549.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	155,156,401,207.74	116,189,877,450.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,787,669,800.00	28,223,850,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,787,669,800.00	28,223,850,400.00
1330	Төсвийн захирагчдаас	139,368,731,407.74	87,966,027,050.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	139,368,731,407.74	87,966,027,050.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	190,524,980,804.12	166,319,946,836.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	190,524,980,804.12	166,319,946,836.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,804,830.00	199,139,652.51
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,804,830.00	8,349,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1,320,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,804,830.00	7,029,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	190,789,972.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	190,789,972.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	190,518,175,974.12	166,120,807,183.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	88,962,714,407.12	113,996,286,414.96
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	88,896,685,189.00	113,996,286,414.96
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,029,218.12	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	101,555,461,567.00	52,124,520,768.55
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,555,461,567.00	52,124,520,768.55
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,099,752,185.42	2,803,294,101.48
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,099,752,185.42	2,803,294,101.48
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,407,879,225.66	8,507,631,411.08
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,507,631,411.08	11,310,925,512.56

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
			Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,553,497,779.67	8,553,497,779.67
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-17,030,624.00	-17,030,624.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,536,467,155.67	8,536,467,155.67
9	Тайлант үеийн үр дүн	1,864,648,974.55	1,864,648,974.55
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,401,116,130.22	10,401,116,130.22
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,401,116,130.22	10,401,116,130.22
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-149,219,147.58	-149,219,147.58
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,251,896,982.64	10,251,896,982.64
19	Тайлант үеийн үр дүн	2,240,413,788.88	2,240,413,788.88
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	12,492,310,771.52	12,492,310,771.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	119,293,351,300.00	114,004,636,094.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	119,293,351,300.00	114,004,636,094.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,582,200.00	8,349,680.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,582,200.00	8,349,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,903,300.00	1,320,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,678,900.00	7,029,680.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	119,274,769,100.00	113,996,286,414.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	119,274,769,100.00	113,996,286,414.96
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	119,274,769,100.00	113,996,286,414.96
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	119,293,351,300.00	73,147,773,085.36
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,223,850,400.00	28,223,850,400.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	28,223,850,400.00	28,223,850,400.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	91,069,500,900.00	44,923,922,685.36
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	91,069,500,900.00	44,923,922,685.36
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	8,507,631,411.08
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	11,310,925,512.56

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн данс ашигладаггүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

"Нийгмийн даатгалын сан" гэж тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зорилгоор ажил олгогчийн цалин хөлсний сан, даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгө юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Төсвийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,721.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,507,631.4	11,310,925.5	2,803,294.1
Авлага	2,447,635.4	2,366,140.1	-81,495.3
Нийт хөрөнгө	10,955,266.8	13,677,065.6	2,721,798.8
Өр төлбөр	554,150.7	1,184,754.9	630,604.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,401,116.1	12,492,310.7	2,091,194.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,955,266.8	13,677,065.6	2,721,798.8

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

- ✓ Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өсөхөд малчин, туслах малчин, 0-3 насны хүүхдээ асарч буй эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эхийн төр хариуцах нийгмийн даатгалын шимтгэлийн санхүүжилт, бусад орлого буюу төлбөрийн актын барагдуулалт, хүүгийн орлого, дээд шатны төсөв захирагчаас олгосон санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл, арилжааны банк дахь орлогын төвлөрсөн дансны үлдэгдлийг бүрэн төвлөрүүлээгүй зэрэг нөлөөлжээ.

Банканд байгаа бэлэн мөнгөний үлдэгдлийг тэтгэвэр, тэтгэмжийн төрлөөр нь харуулбал:

д/д	Дансны нэр	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	Үүнээс	
			Төрийн банк	Хаан банк
1	Төвлөрсөн орлогын данс	159.5	2.3	157.2
2	Тэтгэврийн даатгалын сан	10,940.5	4,562.3	6,378.2
3	Тэтгэмжийн даатгалын сан	183.7	23.4	160.3
4	ҮОМШӨ-ний даатгалын сан	26.1	8.9	17.2
5	Ажилгүйдлийн даатгалын сан	1.1	0.3	0.8
Нийт дүн		11,310.9	4,597.2	6,713.7

- ✓ Авлага дансны бууралт нь өмнөх оны төлбөрийн актын барагдуулалттай холбоотой байна.
- ✓ Өглөг дансны өсөлт нь данс андуурч орсон орлого, санхүүжилтийг залруулаагүй өглөгөөр бүртгэсэн, тэтгэмжийн даатгалын санд үүссэн 11, 12 саруудын олгогдоогүй үлдэгдэл, шимтгэлийн орлогын илүү төлөлтийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн зэрэг нөлөөлжээ. Орон нутгийн ээлжит сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн улс төрийн алба хаагчидтай холбоотой ажилгүйдлийн даатгалын өглөг нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хуульд заасан хугацаанд боловсруулан дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн төсвийг анх батлахдаа нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоор 38,712.7 сая төгрөг төвлөрүүлэх, тэтгэвэр, тэтгэмжид 117,606.3 сая төгрөгийг олгохоор баталжээ.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 12 сарын 19-ны өдрийн А/240 дугаар тушаалаар нийгмийн даатгалын сангийн төсөвт өөрчлөлт оруулж 2024 онд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоор 42,160.5 сая төгрөг бүрдүүлэхээр, тэтгэвэр тэтгэмжид 119,293.4 сая төгрөгийг олгохоор баталжээ. Уг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 28,223.9 сая төгрөг, нийгмийн даатгалын төвлөрсөн сангаас 89,720.7 сая төгрөг, нийт 117,944.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр алдагдалтай төсвийн хуваарь баталсан байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоор 50,782.1 сая төгрөгийг бүрдүүлж, 50,622.6 сая төгрөгийг /эрүүл мэндийн даатгалын шимтгэл орсон дүнгээр/ НДЕГ-ын төв дансанд төвлөрүүлсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлээс төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 626.9 сая /эрүүл мэндийн даатгалын шимтгэл хассан/ төгрөг буюу 1.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 28,223.9 сая, нийгмийн даатгалын сангаас 87,966.0 сая, нийт 116,189.9 сая төгрөгийн санхүүжилт авсан нь батлагдсан төсвөөс 1,754.7 сая төгрөг дутуу байна.

Тайлант онд 113,996.3 сая төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжид, 8.3 сая төгрөгийг банкны үйлчилгээний шимтгэлд зарцуулж, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг 2,193.6 сая төгрөг буюу 1.9 хувиар хэмнэж, 1,500.0 сая төгрөгийг НДЕГ-ын төв дансанд буцаан төвлөрүүлжээ. Төсвийн гүйцэтгэл 95.5 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Тэтгэврийн сан	112,280.1	107,495.2	4,784.9	95.7
2	Тэтгэмжийн сан	5,494.9	4,553.6	941.3	82.9
3	Ажилгүйдлийн сан	1,279.3	1,795.2	-515.9	140.3
4	ҮОМШӨ сан	229.2	152.3	76.9	66.4
5	Бусад зардал	9.9	8.3	1.6	83.8
	ДҮН	119,293.4	114,004.6	5,288.8	95.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн

тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд нэмэлт санхүүжилтийн төсвийн данс ашигладаггүй болно.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дүгээр сарын 06-ны өдрийн 161 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн нийт зардлаар сонгож 158,008.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,580.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжилт нь нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хамааралгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгахад тэтгэвэр, тэтгэмжийн зарцуулалтыг мэдээлээгүйд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил илрээгүй

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн аудитаар Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Татаас санхүүжилтийн авлага: Энэ нь ковид цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан илрүүлсэн даатгуулагчийн орлогод ногдуулсан шимтгэлийг чөлөөлж улсаас төлөх шийдвэртэй холбоотой 2020 онд үүссэн байна. Уг авлага нь олон жил болсон тул тодорхой шийдвэр гаргах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 206.6 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд шинэ программ нэвтрүүлсэнтэй холбоотой тухайн программын хэвийн ажиллах нөхцөл бүрдээгүйн улмаас санхүүгийн тайланд залруулга хийсэн байна.

Аудитаар нийт 145.7 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөх зөрчил илрээгүй байна

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хуулийн хэрэгжилттэй холбоотой

1.1 Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн цахим мэдээллийн санд нийгмийн даатгалын сангийн зарцуулалтыг мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын сангийн зарцуулалтыг тэтгэвэр, тэтгэмжийн төрөл бүрээр сар бүр мэдээлэх

1.2 Илрүүлэлт: Нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын арилжааны банкин дахь үлдэгдлийг НДЕГ-ын төв дансанд төвлөрүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын дансны үлдэгдлийг жилийн эцэст төв санд төвлөрүүлэх

Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу гарган зөвлөмж хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн 2025 оны 07 сарын 10-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү .

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Запруулсан		Запруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд шинэ программ нэвтрүүлсэнтэй холбоотой тухайн программын хэвийн ажиллах нөхцөл бүрдээгүйн улмаас санхүүгийн тайлан зөрүүтэй илэрхийлсэн	1	206,588.6			1	206,588.6	1	206,588.6				
ДҮН	1	206,588.6			1	206,588.6	1	206,588.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төвлөрсөн сангийн хаан Банк дахь дансны үлдэгдлийг төвлөрүүлээгүй байна. /2024.12.31-ны 18 цагаас хойш 13.5 сая төгрөг орсныг хасаж тооцлоо /	1	145,759.8					1	145,759.8				
ДҮН	1	145,759.8					1	145,759.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				/мянган төгрөгөөр/	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	1	0					1	0
Шилэн дансны цахим хуудсанд нийгмийн даатгалын сангийн зарцуулалтыг мэдээлээгүй байна.								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн	1	0					1	0

БОЛОВСРУУЛСАН : АХЛАХ АУДИТОР

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЖАЛБАА

Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

2025.04.02

2025.04.02

2025.04.02